



“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

АУДИТЫН ТАЙЛАН

**“ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ
МОНГОЛ” НҮТББ-ЫН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР
ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2024 ОН**

АГУУЛГА

	Хуудас
БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ	1
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	
АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	3
АУДИТЛАСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	4
АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	5
АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	6
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7-15
МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	16-19

“ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ” НҮТББ

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Э.МӨНХЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ: Ц.ЧИМГЭЭ

БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТР : 1030361


БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ УБ хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Юнескогийн гудамж, Далай тауэр 803 тоот

Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: (+976 - 9999 9031)
Утас: (+976 - 9406 9191)

И-мэйл хаяг: ts.chimgee@gmail.com

АУДИТЫН КОМПАНИ:

Нягтлан бодох бүртгэл хяналтын
итгэмжлэгдсэн байгууллага-
УЛИАСТАЙ ВАН АУДИТ ХХК
Утас: 7015 7405, 9911 8571
И-мэйл хаяг: ulistaivanaudit@ubaudit.mn
Вэб хаяг: www.ubaudit.mn
Пэйж хуудас: <https://www.facebook.com/ulistaivan>





“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, бүртгэлийн программ, сургалтын итгэмжлэгдсэн байгууллага

Хаяг : Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-хороо, Чингисийн өргөн чөлөө, “Сүмбэр таур” оффис, 16 давхар, 1605 тоот.

Утас : 99118571, 70157405

Веб хуудас: www.ubaudit.mn

Имэйл : uliastaivanaudit@ubaudit.mn

2024 оны 10 сарын 10 № 253 /24

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ” НҮТББ-ийн УДИРДЛАГАД

Бид “Транспэрэнси Интернэшнл Монгол” НҮТББ-ийн (цаашид “ТББ” гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Зөрчилгүй дүгнэлт

Танай байгууллага нь 2023 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлангаа холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв тайлагнасан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх хариуцлагыг энэ тайлангийн “Аудиторын санхүүгийн хүлээх үүрэг, хариуцлага” хэсэгт харуулсан болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүрэг бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудиторын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй зүйлсийг аудитын гол асуудал гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хамраагүй тул түүнд баталгаажуулалт гаргахгүй.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлангийн холбогдох олон улсын стандарт дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын хүлээн үүрэг юм. Энэхүү үүрэгт залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах үүрэг бүхий дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх ажлууд багтана. Удирдлага санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулах үүрэг хариуцлага хүлээсэн байна.

Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм. Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандарт болон Аудитын дотоод стандартыг баримтлан хийв. Аудит хийхдээ аудитын горим (шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, тасалбар болгох, тулгах гэх мэт)-уудыг ашиглав. Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан бөгөөд цаашид ч уг зарчмыг баримтлах юм байна.

Тайлангийн зориулалт

Энэхүү тайланг танай байгууллагын хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэв. Бид энэ тайлангийн агуулгын хүрээнд гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК


**"ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ" НҮТББ
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи**

		(мянган төгрөг)	
		<u>2022.12.31</u>	<u>2023.12.31</u>
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	4	29,883	3,718
Дансны авлага	5	-	14,000
Үндсэн хөрөнгө	6	6,804	299
Нийт хөрөнгийн дүн		<u>36,687</u>	<u>18,017</u>
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	7	824	-
Урьдчилж орсон орлого	7	161,651	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн		<u>162,475</u>	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
Өр төлбөрийн нийт дүн		<u>162,475</u>	-
Цэвэр хөрөнгө			
Хязгаарлалтгүй	8	2,970	2,970
Хуримтлагдсан үр дүн	9	(128,757)	15,047
Цэвэр хөрөнгийн дүн		<u>(125,788)</u>	<u>18,017</u>
Өр төлбөр цэвэр хөрөнгийн дүн		<u>36,687</u>	<u>18,017</u>



Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



"Улиастай ван аудит" ХХК

"ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ" НҮТББ

АУДИТЛАГДСАН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН


2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

(мянган төгрөг)

	2022.12.31	2023.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлого		
Хөтөлбөр, төслийн орлого	10 154,774	310,547
Бусад орлого	10 -	23
Үндсэн үйл ажиллагааны орлогын нийт дүн	154,774	310,570
Үндсэн үйл ажиллагааны зардал		
Бэлэг, хандив ба тусламж	207,875	116,670
Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	11 207,875	116,670
Ерөнхий удирдлагын зардал	13 5,842	3,497
Цалин хөлс, шагнал	12 45,070	110,478
Нийгмийн даатгалын шимтгэл	12 6,594	15,854
Ашиглалтын зардал	12 410	753
Түрээсийн зардал	12 20,608	22,712
Албан төмилөлтийн зардал	12 17,352	20,406
Элэгдлийн зардал	12 6,505	6,465
Зар сурталчилгааны зардал	12 800	-
Шуудан, холбооны зардал	12 3,457	4,574
Шатахууны зардал	12 1,964	2,524
Шагнал, урамшууллын зардал	12 4,860	-
Бусад зардал	12 327	-
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	321,663	303,933
Үндсэн үйл ажиллагааны үр дүн	(166,889)	6,637
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал		
Тагварын зардал	-	-
Бусад зардал	-	-
Онцгой шинжтэй зүйлс(цэвэр дүнгээр)		
Тайлант үеийн цэвэр үр дүн	(166,889)	6,637



Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



"Улиастай ван аудит" ХХК


"ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ" НҮТББ
АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

(мянган төгрөг)

	Хязгаарлалтгүй нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,970	-	(128,757)	(125,788)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Залруулсан үлдэгдэл	2,970	-	(128,757)	(125,788)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт /бууралт/	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт /бууралт/	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлангийн үеийн цэвэр үр дүн	-	-	-	-
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,970	-	(128,757)	(125,788)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			137,168	137,168
Залруулсан үлдэгдэл		-	8,411	8,411
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	-	-	-	-
Тайлангийн үеийн цэвэр үр дүн	-	-	6,637	6,637
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,970	-	15,047	18,017



Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



"Улиастай ван аудит" ХХК


"ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ" НҮТББ
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

(мянган төгрөг)

	<u>2022.12.31</u>	<u>2023.12.31</u>
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Үйл ажиллагааны мөнгөн орлого</u>	154,773	310,570
Төсөл хөтөлбөрөөс хүлээн авсан мөнгө	154,773	310,547
Бусад	-	23
<u>Үйл ажиллагааны мөнгөн зарлага</u>	334,978	336,735
Ажилчдад олгосон мөнгө	45,070	110,478
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	6,594	15,854
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	27,451	28,477
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	410	753
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	1,964	2,524
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	20,608	19,238
Хүүний төлбөрт төлсөн мөнгө	227,694	159,411
Татварын байгууллагад төлсөн мөнгө	4,860	-
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	327	-
<u>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</u>	<u>(180,205)</u>	<u>(26,165)</u>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого	-	-
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	-	-
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Банкнаас авсан зээл	-	-
Валютын ханшны зөрүү	-	-
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(180,205)</u>	<u>(26,165)</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	210,088	29,883
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>29,883</u>	<u>3,718</u>



Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



"Улиастай ван аудит" ХХК

“ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ” НҮТББ
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Транспэрэнси Интернэшнл Монгол” НҮТББ нь Монгол Улсын “Төрийн бус байгууллагын тухай” хууль болон бусад холбогдох хуулийн дагуу 2009 оны 12 дугаар сарын 11-ны өдрөөс нийгэмд шударга ёсны тогтолцоог хөгжүүлэн төлөвшүүлэх, авилгал, хээл хахуультай тэмцэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

Нягтлан бодох бүртгэлийн үндэс

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол улсын зохих хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн.

Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

НҮТББ-ын үйл ажиллагааны валют нь Монгол Улсын үндэсний валют төгрөг юм. Хавсаргасан санхүүгийн тайланг нэгжийн оронг төгрөгөөр бэлтгэсэн.

Үнэлгээ

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн.

Нягтлан бодох бүртгэлийн суурь

НҮТББ нь нягтлан бодох бүртгэлийн аккурэл суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

Санхүүгийн тайланг бэлтгэх төсөөлөл

НҮТББ нь одоо болон алсын ирээдүйд үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

3. НИЯТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө нь ТББ-ын касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банк дахь харилцах данснаас бүрдэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэдэг. Гадаад валютаархи мөнгөн хөрөнгийг Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаар хийгддэг мөнгөн хөрөнгийн зүйлсийн ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төгрөг валютаар давхар бүртгэдэг.

Түүхэн өртгөөр тодорхойлогдсон гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Зах зээлийн үнээр илэрхийлэгдсэн гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийг түүний өртгийг тодорхойлох үед байсан албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд балансын өдрөөр Монголбанкнаас зарласан албан ханшаар ханшийн тэгшитгэл хийж, ханшийн өөрчлөлтийн улмаас гарсан зөрүүг ханшийн тэгшитгэлийн олз гарзаар хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ханшийн зөрүүгийн бодит бус олз ба гарз байна.

Валютын солилцоо, арилжааны явцад үүсэн ханшийн зөрүүг валютын арилжааны олз, гарзаар хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ханшийн зөрүүгийн бодит олз ба гарз байна.

Бусад авлага, урьдчилж төлсөн тооцоо

Байгууллага, иргэдэд буцаан төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон мөнгө, худалдан авах бараа, үйлчилгээний үнийн урьдчилгаа, татвар шимтгэлийн авлагыг бусад авлага, урьдчилж төлсөн тооцоонд бүртгэдэг.

Эдгээр авлага, тооцоог нөхөлтийн өртөг буюу төлсөн мөнгөний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

Бараа материал

Бараа материалыг өртөг зах зээлийн үнийн аль багаар нь санхүүгийн тайланд тусгадаг. Өртөг нь бараа материалыг худалдан авахтай холбогдсон зардлаас бүрддэг. Бараа материалыг зарлага болгохдоо дундаж өртгийн аргыг хэрэглэдэг.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлаганана.

Анхны өртөг нь хөрөнгийг худалдан авсан үнэ дээр түүний олж бэлтгэхэд гарсан зардал, капиталжуулсан засварын зардлыг нэмсэн дүнгээс бүрддэг.

“ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ” НҮТББ

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

Үндсэн хөрөнгийн үнэ цэнийг тогтмол хянаж, дансны үнэ, балансын өдрөөрхи бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гарсан нөхцөлд дахин үнэлгээ хийнэ.

Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоохдоо зах зээлийн өнөөгийн үнэ үнээр тодорхойлно. Мэргэжлийн үнэлгээчид уг үнийг тогтооно.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэж байвал үнэлгээний нэмэгдлийг өмчөөр хүлээн зөвшөөрдөг. Харин дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэ цэнэ буурч байвал үнэ цэнийн бууралтын алдагдлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүнийг ашиглалтанд орсон хугацаанаас эхэлж, хөрөнгийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож байгуулдаг.

Элэгдэл тооцох арга болон хугацаа нь Монгол Улсын “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн заалтанд нийцэх бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа нь дараахь байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн төрөл	Ашиглагдах хугацаа /жилээр/
Тавилга эд хогшил	10
Компьютер	3
Тээврийн хэрэгсэл	10
Бусад хөрөнгө	10

Үндсэн хөрөнгөнд хийсэн урсгал болон их засварын зардлыг засвар хийх тухай бүр тооцож, бүртгэнэ.

Засварын зардал нь үндсэн хөрөнгийн анхдагч үнэлгээний үед тогтоосон бүтээмжийг дээшлүүлэхүйц, ТББ-ын хүртэх ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхүйц, ашиглагдах хугацааг уртасгахаар байвал тэдгээрийг капиталжуулах ёстой. Бусад засварын зардлыг урсгал засвар гэх бөгөөд тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалдсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг.

Дансны өглөг


ТББ-ын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон зээлээр худалдан авсан бараа, материалын үнэ, хүлээн авсан үйлчилгээний үнэ болон үйл ажиллагааны зардлыг хуримтлуулснаас үүссэн өглөгийг дансны өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Дансны өглөгийг худалдан авсан бараа, үйлчилгээний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

Бусад өглөг

ТББ-ын ажилчидтай цалин, тэтгэвэр болон бусад тооцоогоор үүссэн өглөг болон бусад аж ахуй нэгж, иргэдтэй үүссэн дансны өглөгөөс бусад өр төлбөрийг бусад өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



“Улиастай ван аудит” ХХК

“ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ” НҮТББ

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

Татварын өглөг

Монгол улсын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын санд төлж байгаа аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, өөрөө явагч хэрэгслийн албан татвар болон бусад татвар, хураамжийн өр төлбөрийг татварын өглөг гэж ангилсан.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрт нэг жилээс дээш хугацаанд төлөх бусад байгууллага, хувь хүнд өгөх өглөгийг бүртгэдэг.

Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчдийн өмч нь хувьцаа эзэмшигчдээс оруулсан хөрөнгө, хуримтлагдсан ашгаас бүрдэнэ. Эзэмшигчдийн өмчийг түүхэн өртгөөр нь санхүүгийн тайланд илэрхийдэг.

Хувьцаат капитал нь эзэмшигчдээс оруулсан энгийн хувьцааны дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд нийт дүн нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нийт хувьцааны тоогоор үржүүлсэн дүн байна.

Хуримтлагдсан ашиг нь өмнөх ба тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр үр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

Үйл ажиллагааны зардал

ТББ-ын удирдлагын болон борлуулалтын үйл ажиллагаанд хамаарах зардлыг үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрдөг. Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацаанд ногдох дүнгээр нь Збүртгэдэг.

Болзошгүй өр төлбөр

Болзошгүй өр төлбөр нь ТББ-ын өнгөрсөн үйл явдлын үр дүнд гарах боломжтой үүрэг хариуцлага бөгөөд түүний орших байдал нь ТББ-ын бүрэн хяналтанд ороогүй, зөвхөн ирээдүйд нэг буюу хэд хэдэн үйл явдлын тохиолдол, эс тохиолдлоор батлагдах одоогийн үүрэг хариуцлага юм.

Болзошгүй өр төлбөрийг барагдуулахын тулд эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийг гадагш шилжүүлэх шаардлагатай гэсэн магадлалтай биш, уг үүрэг хариуцлагыг төлөх төлбөрийн дүнг найдвартай хэмжих боломжгүй бол балансад хүлээн зөвшөөрдөггүй.

ТББ-ын орлогын албан татвар

ТББ-ын санхүүгийн жилийн татвар ногдуулах орлого, түүнд ногдуулсан орлогын албан татварыг Монгол Улсын “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн дагуу тодорхойлж тайлагнадаг.

“ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ” НҮТББ
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

Тус хуулийн дагуу 300.0 сая төгрөг хүртэлх татвар ногдуулах жилийн орлогод ТББ-ын тодорхой үйл ажиллагаанаас хамаарч 1 хувиар орлогын албан татвар ногдуулж төлдөг.

Мөн хуулийн дагуу 3.0 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах жилийн орлогод 10 хувиар, 3.0 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300.0 сая төгрөг дээр 3.0 тэрбумаас дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж, орлогын албан татвар ногдуулж төлдөг.

Хувь хүний орлогын албан татвар

Монгол Улсын “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулиар байгууллага ажиллагсад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогоос 10 хувиар хувь хүний орлогын албан татварыг суутгаж, төсөвт төлөх үүрэг хүлээдэг.

Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол Улсын “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу байгууллага ажиллагсад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын дүнгээс даатгуулагчаас 11.5 хувиар, ажил олгогчоос 12.5 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэг хүлээдэг.

Мөн үйл ажиллагааны чиглэлээс хамааран даатгуулагч болон ажил олгогчийн хувийг 2-3 хувиар нэмэгдүүлэн тооцож нийгмийн даатгалын тооцоог хийх үүрэг хүлээдэг.

Нэмэгдсэн өртгийн албан татвар

Монгол Улсын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), ноогдох бараа үйлчилгээний орлогод 10 хувиар тооцож, НӨАТ төлдөг.

“ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ” НҮТББ
2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
(төгрөг)

4. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Ангилал	2022.12.31	2023.12.31
Банкин дах мөнгө	29,883,300.00	3,718,318.00
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	29,883,300.00	3,718,318.00

5. ДАНСНЫ АВЛАГА

Ангилал	2022.12.31	2023.12.31
Дансны авлага	-	14,000,000.00
Дүн	-	14,000,000.00

Санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.



“Улиасгай ван аудит” ХХК

“ТРАНСПЭРЭНСИ ИНТЕРНЭШЛ МОНГОЛ” НҮТББ
 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)

6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Хөрөнгийн ангилал	Тавилга эд хогшил	Компьютер дагалдах хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт
а. Анхны өртөг				
Эхний үлдэгдэл	6,224,000.00	19,220,200.00	3,775,700.00	29,219,900.00
Нэмэгдсэн	-	-	-	-
Хасардсан	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	6,224,000.00	19,220,200.00	3,775,700.00	29,219,900.00
б. Хуримтлагдсан элэгдэл				
Эхний үлдэгдэл	-	19,050,400.00	3,366,000.00	22,416,400.00
Нэмэгдсэн	6,224,000.00	-	280,800.00	6,504,800.00
Хасардсан	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	-	19,050,400.00	3,646,800.00	28,921,200.00
в. Үлдэгдэл өртөг				
Эхний үлдэгдэл	6,224,000.00	169,800.00	409,700.00	6,803,500.00
Эцсийн үлдэгдэл	-	169,800.00	128,900.00	298,700.00

“ТРАНСПОРНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ” НҮТББ
 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)

7. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Ангилал	2022.12.31	2023.12.31
Дансны өглөг	824,000.00	-
ХХОАТ-ын өр	161,650,500.00	-
Дүн	162,474,500.00	-

Нягтлан бодогчийн 2023 оны 12 сарын 31-ээр тайлагнасан урьдчилж орж ирсэн орлого дансны үлдэгдэл болох 137,168,186.00 төгрөгийг аудитын залруулга хийж хуримтлагдсан ашиг руу хаасан болно.

8. ЦЭВЭР ХӨРӨНГӨ

НҮТББ нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2,969,600.00 төгрөгний цэвэр хөрөнгөнөөс бүрдэж байна.

	2022.12.31	2023.12.31
Хязгаарлалтгүй	2,969,600.00	2,969,600.00
Дүн	2,969,600.00	2,969,600.00

9. ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ /ХУВЬЦААНААС БУСАД/


Ангилал	2022.12.31	2023.12.31
Хуримтлагдсан үр дүн	(128,757,300.00)	15,047,418.00
Дүн	(128,757,300.00)	15,047,418.00

Нягтлан бодогчийн 2023 оны 12 сарын 31-ээр тайлагнасан урьдчилж орж ирсэн орлого дансны үлдэгдэл болох 137,168,186.00 төгрөгийг аудитын залруулга хийж хуримтлагдсан ашгийг 15,047,418.00 болгосон.

10. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Ангилал	2022.12.31	2023.12.31
Хөтөлбөр төслийн орлого	154,773,600.00	310,546,919.00
Бусад орлого	-	23,104.00
Дүн	154,773,600.00	310,570,023.00

Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



“Улиастай ван аудит” ХХК

“ТРАНСПОРТНЫ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ” НҮТББ
 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)

11. ТАГААС, САНХҮҮЖИЛГИЙН ЗАРДАЛ

Ангилал	2022.12.31	2023.12.31
Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	207,874,500.00	116,670,158.00
Дүн	207,874,500.00	116,670,158.00


12. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Ангилал	2022.12.31	2023.12.31
Цалингийн зардал	45,069,900.00	110,478,492.00
ЭМ, НДШ-ийн зардал	6,593,900.00	15,853,737.00
Түрээсийн зардал	20,608,000.00	22,712,000.00
Элэгдэл хорогдлын зардал	6,504,800.00	6,464,912.00
Шуудан холбооны зардал	3,457,300.00	4,573,507.00
Шагахууны зардал	1,963,500.00	2,524,469.00
Зар сурталчилгааны зардал	800,000.00	-
Ашиглалтын зардал	410,000.00	752,638.00
Шагнал урамшууллын зардал	4,860,300.00	-
Албан томилолтын зардал	17,351,800.00	20,406,483.00
Бусад зардал	326,500.00	-
Дүн	107,946,000.00	183,766,238.00

13. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Ангилал	2022.12.31	2023.12.31
Бусад зардал	5,842,300.00	3,497,095.00
Дүн	5,842,300.00	3,497,095.00

Санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.



“Улиастай ван аудит” ХХК



Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Удирдлагын анхаарах шаардлагатай болон аудитын явцад бидний ажигласан бөгөөд цаашид санал дүгнэлтэнд нөлөөлөх магадлалтай асуудлууд:

Асуудал 1:

Урьдчилж орсон орлогын залруулгын талаар

Асуудал 2:

Ерөнхий журнал хөтлөн санхүүгийн тайлан гаргаж байх талаар

2024 оны 10 сарын 09

Менежментийн захидал

Манай компани нь аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно.

Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь танай компанийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Манай компани нь эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар авч үзвэл:

Тэргүүлэх ач холбогдол №1-д цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул нэн даруй анхаарвал зохих асуудлууд,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Транспэрэнси Интернэшнл Монгол” НҮТББ-ийн захирал О.Батбаяр, нягтлан бодогч Ц.Чимгээ болон санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1 Урьдчилж орж ирсэн орлогын залруулгын талаар:	
---	--

Ажиглалт

Тус байгууллагын нягтлан бодогчийн боловсруулсан санхүүгийн байдлын тайланд тусгагдсан урьдчилж орж ирсэн орлого дансны үлдэгдэл 161,651,000.00 төгрөг нь 2016 оноос үүссэн байна. Тухайн зөрүүг хөөн шалгаж 2016 оны жилийн эцэст орлогоо буруу хүлээн зөвшөөрсөнөөс болж үүссэнийг олж тогтоон залруулах шаардлагатай байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3. “бүх өр төлбөрийг заавал бүртгэнэ” заалтыг зөрчсөн.

Зөвлөмжүүд

Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнах, залруулах

Бичилт 1:

ДТ Урьдчилж орж ирсэн орлого
 161,651,000.00

КТХуримтлагдсан ашиг, алдагдал
 161,651,000.00

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3. “бүх өр төлбөрийг заавал бүртгэнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Эрсдэлүүд

Татвар болон санхүүгийн тайлангийн тоон мэдээллүүд зөрүүтэй байгаагаас үүдэн санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж улмаар татварын эрсдэлд орох эрсдэлтэй.

Асуудал 2

Ерөнхий журнал хөтлөн санхүүгийн тайлан гаргаж байх талаар:

Ажиглалт

Тус байгууллагын нягтлан бодогчийн бэлтгэсэн “Санхүүгийн тайлан”-ийн нэг хэсэг болох Ерөнхий журнал болон гүйлгээ балансыг тулган шалгахад бэрхшээлтэй байсан ба тоонууд таарахгүй байсан. Улмаар Ерөнхий журнал хөтөлж санхүүгийн тайлан гаргаагүй байна. Энэхүү байдал нь нягтлан бодох тухай хуулийн дараах заалтыг зөрчсөн.

14.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ:

- 14.3.1. анхан шатны баримт бүрдүүлэх;
- 14.3.2. журналд бичих;
- 14.3.3. дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх;
- 14.3.4. ажил, гүйлгээний мэдээ гаргах;
- 14.3.5. санхүүгийн тайлан гаргах.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан гаргах дараалал буруу байгаагаас үүдэн санхүүгийн тайлан болон татварын тайлан үнэн зөв гарах боломжгүй.

Зөвлөмжүүд

Стандарт шаардлагад нийцсэн санхүүгийн програм байгууллагадаа ашиглах,

Excel програм ашиглан стандартын дагуу Санхүүгийн тайлангаа гаргаж хэвших,

Хуульд заасан заалтын дагуу санхүүгийн тайлангаа гаргаж хэвших.

Үйлчлүүлэгчийн хариу